



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР**

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Зам, тээврийн салбарын
хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд
авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг үндэслэн ДААЛГАХ НЬ:

Зам, тээврийн салбарын хэмжээнд хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, олон улсын жишиг хандлагад нийцсэн өрсөлдөх, хөрвөх чадвар бүхий мэргэжилтэй ажилтнуудын тоог нэмэгдүүлэх, албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах, сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааны түншлэлийг хөгжүүлэх замаар салбарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллах зорилтын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, харьяа байгууллага, салбарын төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компаниуд, төрийн бус байгууллагын удирдлага, захирлуудад дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай. Үүнд:

1. Хүний нөөцийн бодлогын чиглэлээр:

1.1. Байгууллага бүр хүний нөөцийн стратеги, хөтөлбөр, хүний нөөцийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулан батлуулах;

1.2. Зам, тээврийн мэргэжлийн боловсрол, сургалтын салбар зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд төлөөлөл оролцуулж, хамтран ажиллах;

1.3. Салбарын хүний нөөцийн мэдээллийг нэгтгэх ажлын хүрээнд Зам, тээврийн салбарын нэгдсэн платформд байгууллага бүр хүний нөөцийн мэдээллийн системээ холбох арга хэмжээ авах;

2. Ажлын байрны орчин, нөхцөлийг сайжруулах чиглэлээр:

2.1. Төрийн өмчит үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэх, өөрчлөлт оруулахдаа Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр баталж байх;

2.2. Салбар бүрийн чиглэлээр байгуулсан гурван талт хамтын хэлэлцээрийн дагуу албан хаагчдын цалин, урамшууллыг нэмэгдүүлэх, албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

080000020

2.3. Албан хаагчдыг давтан сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах чиглэлд суралцагсдын тоог нэмэгдүүлэн хүний нөөцөө хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.

2.4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, тухайн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллах;

3. Хүний нөөцийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох, нийлүүлэлтийг хангах чиглэлээр:

3.1. Хүний нөөцийн эрэлт, хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийж, хүний нөөцийн системдээ цаг алдалгүй оруулах ажлыг зохион байгуулах;

3.2. Салбарын хэмжээнд шаардлагатай мэргэжлийн жагсаалтыг гаргаж, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан сургуульд суралцагчдад дэмжлэг үзүүлэх, байгууллагын захиалгаар хүний нөөц бэлтгэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;

3.3. Гадаад улсын Засгийн газрын тэтгэлгээр суралцах мэргэжлийн жагсаалтад зам, тээврийн салбарын мэргэжлийн тоо, квотыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

3.4. Салбарын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг гадаад орнуудын их дээд сургуулиудыг судлан хамтын ажиллагааны түншлэлийг өргөжүүлэн санамж бичиг, гэрээ байгуулах чиглэлээр ажиллах;

3.5. Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх МСҮТ-ийг салбарын төрийн өмчит болон хувийн хэвшлийн компаниудын дэргэд байгуулах, сургалтын бааз суурийг сайжруулах чиглэлд дэмжлэг үзүүлэх.

3.6. Гадаад болон дотоодын их дээд сургуульд байгууллагын зардлаар сурсан оюутан, албан хаагчидтай багадаа 3 жилийн гэрээ байгуулан тогтвортой ажиллуулах арга хэмжээг авах;

3.7. Зам, тээврийн салбарын эрэлттэй мэргэжлээр суралцаж буй оюутныг дадлагажуулан, ажлын байраар хангах арга хэмжээг авах;

3.8. Ажлын байрны сул орон тоог сонгон шалгаруулах ажлыг нээлттэй, ил тод зохион байгуулах.

4. Салбарын хүний нөөцийн хөгжлийг олон нийтэд сурталчлах, мэдээлэх чиглэлээр:

4.1. Салбарын мэргэжлээр гадаадын их дээд сургуулиудад сурч буй оюутнуудыг агаарын болон төмөр замын тээвэр, авто тээврээр хөнгөлөлттэй зорчих нөхцөлийг бүрдүүлэх;

4.2. Монгол Улсын төрийн далбааг мандуулсан далайн хөлөг онгоц дээр далайчныг дадлагажуулах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;

4.3. Гадаад, дотоодын их сургууль, МСҮТ-д сургах мэргэжил, хөнгөлөлт, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, мэдээлэх;

5. Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг харьяа байгууллага тус бүр батлан, хэрэгжилтийг улирал бүр Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнах, гарсан үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг харьяа байгууллагын дарга, захирал нарт даалгасугай;

6. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг улирал тутам танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Болор-Эрдэнэ), Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ